



**“АМЬСГАЛАХ ЭРХ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД
АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД ИРГЭДЭД
ТУЛГУУРЛАН ХИЙСЭН**



МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН



PM 2.5



УЛААНБААТАР ХОТ
2019

МОНИТОРИНГИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

БАГИЙН АХЛАГЧ:

П.Цэцгээ (МХЭХ)

ЗӨВЛӨХ:

Н.Эрдэнэсайхан (PhD),
Д.Сүнжид (PhD)

БАГИЙН ГИШҮҮД:

С. Цэрэнпүрэв (Захиргааны шинэ санаачлага ТББ)

М.Чинзориг (Эрэгтэйчүүдийн холбоо ТББ)

А.Оюунчимэг (Булаг шанд гол мөрийн эхийг хамгаалах сан ТББ)

С. Наранцогт (Уст төгөл ТББ)

Ц.Нарангэрэл, Ц.Одгэрэл (Нийгмийн бодлого хөгжил судалгааны төв ТББ)

Ж.Намбардулам (Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо)

ХОЛБОО БАРИХ



Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо

Монгол улс, Улаанбаатар 210646, Сүхбаатар дүүрэг, Залуучуудын өргөн чөлөө, 6-р хороо, 2/1, Ш/Х-547, Утас/факс: 11-322212

Facebook-[https://www.facebook.com/Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо](https://www.facebook.com/Монголын_хуульч_эмэгтэйчүүдийн_холбоо)

И-мэйл: mwla1992@gmail.com



Пипл Ин Нийд ОУТББ




Амьсгалах эрх төсөл

Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, 1-р хороо, 8-1 тоот

Пипл Ин Нийд ОУТББ, Утас: 70111501

Facebook-<https://www.facebook.com/PINinMongolia>

АГУУЛГА

	ТОВЧИЛСОН ҮГ	4
	ОРШИЛ	5
	МОНИТОРИНГИЙН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АРГА ЗҮЙ	7
	МОНИТОРИНГИЙН АЖЛЫН 5 ДҮҮРГИЙН НЭГДСЭН ҮР ДҮН	8
	Иргэдээс авсан асуулгын дүн шинжилгээ	9-16
	Аж ахуй нэгжүүдээс авсан асуулгын дүн шинжилгээ	17-19
	Сайжруулсан шахмал түлш борлуулагчдаас авсан асуулгын дүн шинжилгээ	20-22
	ДҮГНЭЛТ	23
	ЗӨВЛӨМЖ	26

ТОВЧИЛСОН ҮГ

ААН	Аж ахуйн нэгж
БЗД	Баянзүрх дүүрэг
ЗГ	Засгийн газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ОУТББ	Олон улсын Төрийн бус байгууллага
СШТ	Сайжруулсан шахмал түлш
СБД	Сүхбаатар дүүрэг
ТББ	Төрийн бус байгууллага
УБ	Улаанбаатар
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
ШТ	Шахмал түлш
ШТБЦ	Шахмал түлш борлуулах цэг

ЭХ БЭЛТГЭЛ, ГРАФИК ДИЗАЙН

“Чадамжид суурилсан боловсролыг дэмжих төв” ТББ-д бэлтгэв.

Г.Сарнай, М.Архөвч

www.cbe.mn
Утас: 94080553



ОРШИЛ

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулж, оршин суугчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор Агаарын тухай хууль (16.1.5- Улаанбаатар хотын хэмжээнд түүхийн нүүрс болон агаар бохирдуулах бусад хаягдал зүйлс шатаахыг хориглосон), Улсын Их Хурлын 2018 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн 2 дугаар тогтоол (“... чанар стандартын шаардлага хангасан утаагүй шахмал түлшний үйлдвэрлэл эрхлэгчдийг төрийн оновчтой бодлогоор дэмжих, зохист хэмжээнээс их хорт утаа ялгаруулж байгаа ... зориулалтын бус түлш хэрэглэн химийн хорт бодис ялгаруулж агаарын чанар, нийгмийн эрүүл мэндэд хохирол учруулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг чангатгаж, таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлэх”), Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батласан “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” (гэр хорооллын айл өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах, сайжруулсан түлшний үйлдвэрлэлийг дэмжин түүхий нүүрсний хэрэглээг орлуулах) зэрэг хууль тогтоомжуудын биелэлтийг хангах ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газар 2018 онд “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолыг батлан гаргаж, 2019 оны 05 сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөн хэрэгжүүлж эхэлсэн.

Монгол Улсын Засгийн газраас түүхий нүүрс хэрэглэхийг Улаанбаатар хотын хэмжээнд хориглож, үүний оронд шаталт, эрчим сайтай сайжруулсан шахмал түлшийг хэрэглүүлснээр агаарын бохирдлыг


60-80 хувь бууруулна гэж тооцож байгаа бөгөөд Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 6 ба 7 дугаар шалгуур үзүүлэлт “түүхий нүүрсний хэрэглээг халж, сайжруулсан түлш хэрэглэх өрхийн тоо 23,000-д хүрэх”, “сайжруулсан түлшний үйлдвэрлэлийн хэмжээ жилд 90,000тн болох” зорилтыг бүрэн хангана гэж үзжээ. Нэг талаас УИХ, Засгийн газар ийнхүү агаар орчны бохирдлыг бууруулах эрх зүйн орчин, тодорхой хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүтэц, санхүүжилтийг бий болгон ажиллаж эхлээд байна. Нөгөө талаас гэр хорооллын иргэдийн идэвхитэй оролцоо, хамтын ажиллагаа агаарын бохирдлыг бууруулахад үнэтэй хувь нэмэр оруулахаар байна.

Европын холбооны санхүүжилтээр Пипл Ин Нийд ОУТББ, Монголын Байгаль орчны иргэний зөвлөл, Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо, Гэр зураглал төв ТББ-уудаас хамтран хэрэгжүүлж буй Амьсгалах Эрх төслийн хүрээнд Засгийн газрын “Түүхий нүүрсийг хэрэглэхийг хориглох тухай” тогтоол

1. УБ хотын төвийн зорилтот 5 дүүргийн гэр хорооллуудад хэрхэн хэрэгжиж байгаа,
2. Гэр хороололд амьдарч байгаа айл өрхүүдэд тэр дундаа нийгмийн эмзэг бүлгийн өрх айлуудад үзүүлж буй нөлөөлөл,
3. Сайжруулсан шахмал түлшийг хэрэглэх талаарх иргэдийн сэтгэл ханамжийн байдал,
4. Уг тогтоолыг гаргахад болон хэрэгжүүлэх явцад олон нийтийн оролцоо болон
5. Мэдээллийн ил тод байдал хэрхэн хангагдаж байгаа зэрэг таван ерөнхий үзүүлэлтээр олон нийтийн дунд мониторинг хийсэн.

5 ДҮҮРЭГ, 36 ХОРОО

МОНИТОРИНГИЙН 5 БАГ



Мөн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийн явцыг үнэлж, цаашид энэ тогтоолын хэрэгжилтийг сайжруулах, тэргүүн туршлага, сайн жишээг бусад дүүрэг, хороодод түгээн дэлгэрүүлэх зорилгоор Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сүхбаатар дүүргийн гэр хорооллын хамгийн их бохирдолтой бүсийн 36 хороодод 5 төрийн бус байгууллагын оролцоотой бүхий мониторингийн багаас 2019 оны 7, 8, 9, 10 дугаар саруудад ажиллаж, зохих үр дүнг гаргаад байна.

Мониторингийн хугацаанд зорилтот дүүрэг хороодын түлш хэрэглэн халаалтын хэрэгцээгээ хангадаг гэр хорооллын иргэд болон эмзэг бүлгийнхэн, бие даасан халаалттай ААН, жижиг бизнес эрхлэгчид болон сайжруулсан шахмал түлшний бөөний болон жижиглэнгийн борлуулагч нартай уулзаж асуулга авах, иргэдийн бүлэг болон дүүргийн байгаль орчин агаарын бохирдлын асуудал хариуцсан мэргэжилтэнүүдтэй ярилцлага хийх, бодит байдалд ажиглалт явуулах зэрэг арга замаар мониторингийг

гүйцэтгэсэн болно. Түүхий нүүрсийг халах, сайжруулсан шахмал түлшний олдоц, үнэ, хэрэглээ, хадгалалт, нөөцлөлийн талаарх санал хүсэлт, мэдээлэл, ажлыг сайжруулах зөвлөгөөг авч, мониторингийн үр дүнд нэгтгэн ажил хариуцсан Яам, агентлаг, хотын, дүүргийн удирдлага болон бусад шийдвэр гаргагч, хэрэгжүүлэгч нарт танилцуулан, төлөвлөлт, бодлогын хэрэгжилтийг улам сайжруулах агаарын бохирдлыг бодитой бууруулахад тус дэм болно гэж найдаж байна.

Энэхүү тайланд мониторингийн багийн 2019 оны 7-10 сард хийж гүйцэтгэсэн хоёр хугацааны тайлангийн харьцуулсан үр дүн, иргэдийн бүлгийн ярилцлагын болон мониторингийн тайлан хэлэлцүүлгээс гарсан саналуудыг тусгасан болно.

Мөн Пипл Ин Нийд байгууллагаас Амьсгалах эрх төслийн хүрээнд 2019 оны 5 сард хийсэн Улаанбаатар хотын 5 дүүргийн иргэдийн сайжруулсан түлшний талаарх мэдлэг ойлголт, хандлагын судалгааны үр дүнг ашиглан, харьцуулалт хийсэн.



Энэхүү мониторингийн ажлын зохион байгуулалт, агуулга, үр дүнгийн талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл:



П.Цэцгээ
(Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн холбоо ТББ-ын гүйцэтгэх захирал)



tsetsgee1921@gmail.com



Судалгааны арга зүй, зөвлөмжтэй холбоотой мэдээлэл, шүүмжлэл, санал хүсэлт байвал:

Мониторингийн зөвлөх



Н.Эрдэнэсайхан Ph.D



erdene@environ.mn



Д.Сүнжид Ph.D



sunjid.dugar@gmail.com



МОНИТОРИНГИЙН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АРГА ЗҮЙ

“Амьсгалах эрх” төсөл нь ТББ-уудыг чадавхжуулах замаар агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулах боломжийг нэмэгдүүлэх, Агаарын бохирдлын тухай мэдээллийн хүртээмжтэй системийг бүрдүүлж, агаарын бохирдлын талаар явуулж буй засгийн газрын үйл ажиллагааны ил тод хариуцлагатай байдлыг дээшлүүлэх зорилготой 2018-2019 онуудад хэрэгжиж буй бөгөөд уг төслийн хүрээнд Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо ТББ иргэд, хувийн хэвшил, төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, төрийн агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилт, үүнд иргэд, ТББ-уудын оролцоо, мэдээллийн хүртээмж зэрэгт мониторингийн ажлыг зохион байгуулах, идэвхи санаачлагатай ТББ-иудын дунд мониторинг хийх сургалт зохион байгуулж, чадавхижуулсаны үндсэн дээр мониторинг хийхэд оролцуулах, мониторингийн үр дүнгээр төрийн бодлого боловсруулах, дүгнэх, иргэдийн идэвхитэй оролцоог хангах, бодлогод эерэгээр нөлөөлөх зэрэг ажлыг хариуцан ажиллаж байгаа билээ.

Эхний ээлжинд агаар, орчны бохирдолд мониторинг хийх чиглэлээр УБ хот болон орон нутгийн идэвхитэй ажилладаг 50 ТББ-уудын төлөөлөл 30 хүнд 2 өдрийн сургалтыг 2019 оны 4 дүгээр сарын 12-16 ны өдрүүдэд зохион байгуулж, төрийн бодлого, бодлогын боловсруулалт, хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, дэмжлэг, мониторингийн ажлын

зорилго, зохион байгуулалт, дүгнэлт, үр дүнг тайлагнах зэрэг сэдвүүдээр хичээл зааж, бие даан мониторинг хийх дасгал, дадлага хийлгэн чадавхижууллаа. Сургалтын явцад идэвхтэй оролцсон Улаанбаатар хотын 5 ТББ-ыг сонгон авч Агаарын бохирдлыг бууруулах бодлогын хүрээнд УБ хотод түүхий нүүрс хэрэглэхийг хориглох, сайжруулсан шахмал түлшээр гэр хорооллынхныг хангах шийдвэрийн хэрэгжилт, ажлын явц байдалд мониторинг хийхэд оролцуулав.

Судалгааны баг мониторингийг УБ хотын агаарын чанарын их бохирдолтой 1, 2 дугаар бүсүүдэд байрлах Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Баянзүрх дүүргийн 36 хороодын иргэдийн төлөөлөл, эмзэг бүлгийнхнийг оролцуулан нийт 946 иргэн, бага оврын уурын зуух ашигладаг жижиг дунд бизнес, худалдаа, үйлчилгээ эрхлэгч ААН (36 үйлчилгээ, худалдаа эрхлэгч), болон сайжруулсан шахмал түлш жижиглэн ба бөөнөөр борлуулагч (33 борлуулагч) гэсэн 4 бүлгийн нийт 1015 хүнийг санамсаргүй байдлаар сонгон урьдчилан бэлтгэсэн 5 чиглэлийн 15 асуулгын дагуу нүүр тулсан ярилцлага хийх, ажиглах зэрэг аргаар мэдээллийг цуглуулан боловсруулж, дүн шинжилгээг хийлээ. Эдгээр сонгон авсан 946 иргэн нь мониторинг хийж буй 5 дүүргийн дүүрэг тус бүрээс 184-193 хүн буюу 19-20 хувь, гэр хороололд оршин суудаг нийт 375 мянган оршин суугчдын 2.5 хувийн төлөөлөл болж байна.

15 асуулга



Ярилцлага
хийх

Ажиглах

Иргэд, ААН



МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ
АРГА

Бусад



МОНИТОРИНГИЙН АЖЛЫН 5 ДҮҮРГИЙН НЭГДСЭН ҮР ДҮН

Түлш хэрэглэн халаалтын хэрэгцээгээ хангадаг хэрэглэгчид



Судалгаа авах явцад СШТ-ний олдоц, хэрэглээний тухай мэдээллийн талаар иргэд болон эмзэг бүлгийнхний хооронд мэдлэгийн ялгаа байхгүй байсан бөгөөд мэдээлэл авах эх сурвалж ижил тул эдгээр хоёр бүлгийн мэдээллийг нэгтгэн гаргасан. Цаашид эдгээр хоёр бүлгийг нэг болгон тооцсон болно.

Харин хүйтний улиралд эмзэг бүлгийнхний амьжиргааг дэмжих үүднээс Нийслэл, дүүрэг, хороодоос СШТ-ний үнийг хөнгөлөн олгох бодлого, хүргэлтийн үйлчилгээг зохион байуулах талаар эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах хэрэгцээ шаардлага байна.

Судалгаанд хамрагдсан оролцогчдыг нэгтгэсэн дүн

5 ДҮҮРЭГ, 36 ХОРОО

	Нийт	Иргэн		ААН		СШТ борлуулагч	
		946		36		33	
Сонгинохайрхан		192	20.3%	6	16.7%	8	24.2%
Сүхбаатар		193	20.4%	13	36.1%	6	18.2%
Чингэлтэй		184	19.5%	12	33.3%	10	30.3%
Баянзүрх		188	19.9%	5	13.9%	1	3.1%
Хан-Уул		189	19.9%	0	0%	8	24.2%



Ерөнхий мэдээлэл

- 1 Респондентийн хувийн мэдээлэл (овог нэр, оршин суугаа хаяг, ам бүлийн тоо, холбоо барих утас)
- 2 Амьдарч буй хаяг дээрх хашаа, байшингийн өмчлөлийн хэлбэр (өмчилсөн, эзэмшиж буй, түрээслэсэн, хамаатан садны хашаанд суугч, эсвэл айлын хашаанд түр суурьшсан зэргээс хамаарч ашиглаж буй түлшний төрөл, хэмжээ, галлагааны хэлбэр, горим, түлшний хадгалалт, худалдан авалт янз бүр байна)
- 3 Амьдарч буй гэр, сууцны төрөл (гэр, өөрийн барьсан байшин, түрээсийн байр)
- 4 Ашигладаг зуух, пийшингийн төрөл (ердийн зуух, төслийн зуух, ердийн пийшин, ханан пийшин, нам даралтын зуух)
- 5 Хүйтний улиралд зарцуулдаг түлшний төрөл хэмжээ (нүүрс, мод, шахмал түлш)



Үндсэн мэдээлэл

- 6 Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай ЗГ-ын 62-р тогтоолын тухай мэдлэг
- 7 Мэдээллийг авсан эх сурвалж (хороо, хэсгээс, хэвлэл мэдээллийн хэрэгслээс, олон нийтийн цахим сүлжээнээс, хөрш болон хамаатан садан, бусад иргэдээс сонссон, эсвэл өөр эх үүсвэрийг нэрлэх)
- 8 Төр захиргааны байгууллагуудаас ЗГ-ын түүхий нүүрсний хэрэглээг хориглох талаар яриа таниулга, сурталчилгаа ард иргэдэд хүрсэн эсэх
- 9 Сайжруулсан шахмал түлшний талаарх мэдээллийн хүртээмж (хаанаас түлш авах гэж байгаа, шахмал түлш борлуулах цэгийг (ШТБЦ) мэдэх эсэх, ШТБЦ-ийн байршил тохиромжтой эсэх, түлшний үнэ цэнийн талаар мэдээлэлтэй эсэх, ШТ борлуулах цэгийн байршлыг тогтооход иргэдийн саналыг авсан эсэх)
- 10 Сайжруулсан шахмал түлшний хэрэглээг хэрхэн үнэлж байгаа (сайн, дунд, муу, мэдэхгүй)
- 11 Түлш худалдан авдаг давтамж (хүйтний улиралд бөөнөөр, сар бүр, 5-10 хоногт нэг удаа, өдөр бүр, мөнгөтэй болохоороо худалдаж авдаг.)
- 12 СШТ-ийг хадгалах байр савны нөхцөл (түлш хадгалах байр, сав хангалттай, түлшийг хадгалах байр, савны хэмжээ бага, өдөр бүр шууд ашигладаг.)
- 13 ЗГ-ын 62-р тогтоолын талаар төрийн байгууллагуудаас хийсэн мэдээлэл, сурталчилгаа, тайлбарлан таниулах ажиллагаа



Нэмэлт мэдээлэл

- 14 СШТ-ний олдоц, хэрэгцээ, үнэ, савлагаа, хэрэглээ болон жижиг борлуулах цэгийн байршилтай холбогдсон нэмэлт санал хүсэлт, гомдлын мэдээлэл




Үндсэн мэдээлэл

Асуулга

Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай ЗГ-ын 62-р тогтоолын тухай мэдлэг асуулгад хамрагдсан гэр хорооллын оршин суугчдын дунд ямар байгааг тандахад:

Гэр хорооллын оршин суугч




Дээрх үзүүлэлтээс харахад Улаанбаатар хотын агаар, орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газар “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолыг 2018 онд гаргаж, 2019 оны 05 сарын 15-ны өдрөөс дагаж мөрдөн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ тогтоолын талаар 8 сарын асуулгад хамрагдсан 5

дүүргийн сонгон авсан 36 хорооны гэр хорооллын 480 оршин суугч иргэдийн 341 буюу 71 хувь нь, 10 сард явуулсан асуулгад оролцсон мөн дүүрэг хорооны 466 иргэнээс 371 буюу 79.6 хувь нь ямар нэг байдлаар мэдээлэл авсан байна. Өөрөөр хэлбэл 10 сард мэдээлэлтэй иргэдийн тоо 9 орчим хувиар нэмэгдсэн байв.

Асуулга

ЗГ-ын 62-р тогтоолын тухай мэдээллийг авсан эх сурвалж (хороо, хэсгээс, хэвлэл мэдээллийн хэрэгслээс, олон нийтийн цахим сүлжээнээс, хөрш болон хамаатан садан, бусад иргэдээс сонссон, эсвэл өөр эх үүсвэрийг нэрлэх)




Энэ тогтоолын талаарх мэдээллийг 8 сарын асуулгад оролцсон 219 иргэн буюу 46 хувь нь хэвлэл, мэдээллийн хэрэгслээс сонссон, 189 буюу 38.9 хувь нь хорооны удирдлага, хэсгийн ахлагч нараар дамжуулан авсан, харин 49 буюу 10 хувь нь олон нийтийн

цахим хэрэгслээс авсан байна. 10 сарын байдлаар 183 иргэн буюу 39.3 хувь нь хэвлэл мэдээллийн хэрэгслээс мэдээлэл авсан бол 181 иргэн буюу 38.9 хувь нь хорооны удирдлага, хэсгийн ахлагч нараас сонссон, үлдсэн хэсэг нь бусад эх сурвалжаас авчээ.

Асуулга

Төр захиргааны байгууллагуудаас ЗГ-ын түүхий нүүрсний хэрэглээг хориглох талаар яриа таниулга, сурталчилгаа ард иргэдэд хүрсэн эсэх




Оролцогчдын 200 хүн буюу 41.7 хувь нь 8 сарын судалгаагаар танилцуулга хийсэн гэсэн бол 10 сарын судалгаагаар 42.5 хувь нь танилцуулга хийсэн гэжээ.

Хэдийгээр галлагааны улирал эхэлсэн ч гэсэн Засгийн газрын тогтоолыг иргэдэд хүргэх ажил төдийлөн ахиц гараагүй байна.

Асуулга

СШТ-ний талаарх мэдээллийн хүртээмж (ШТ-ний талаарх мэдлэг ямар байгаа, шахмал түлш борлуулах цэгийг (ШТБЦ) мэдэх эсэх, ШТБЦ-ийн байршил тохиромжтой эсэх, түлшний үнийн талаар мэдээлэлтэй эсэх, ШТ борлуулах цэгийн байршлыг тогтооход иргэдийн саналыг авсан эсэх)



СШТ-ийг хэрэглээний хувьд хэрхэн үнэлж байгаа талаарх иргэдийн хариултыг дүгнэж үзэхэд, түүхий нүүрсийг орлуулах СШТ-ний талаар 8 сард асуулгад оролцсон иргэдээс 330 буюу 68.8 хувь нь мэдэхгүй гэж хариулж

байсан бол 10 сард 127 иргэн буюу 27.3 хувь болж СШТ-ний талаар мэдэхгүй гэсэн иргэдийн тоо 41.5 хувиар буурчээ.

1 СШТ-ийг сайн гэж 8 сард иргэдийн 6.3 хувь нь үнэлж байсан бол 10 сард 23.8 хувь нь сайн гэж дүгнэсэн байна. СШТ хэрэглэж үзсэн нийт 150 иргэнээс 8 сард 52 буюу 34.7 хувь нь муу, 68 буюу 45.3 хувь нь дунд, 30 буюу 20 хувь нь сайн гэж үнэлж байсан бол 10 сарын асуулгаар СШТ хэрэглэсэн нийт 339 иргэний 88 буюу 25.9 хувь нь муу, 140 буюу 41.3 хувь нь дунд, 111 буюу 32.8 хувь нь сайн гэж үнэлжээ.


2 СШТБЦ-ийн байршлын талаар 8 сард асуулгад оролцсон иргэдийн 178 буюу 37.1 хувь нь мэднэ гэсэн бол 10 сард 195 иргэн буюу 41.8 хувь нь мэднэ гэж хариулжээ. СШТ борлуулах үнийн талаар 8 сард 56.6 хувь нь мэдэж байсан бол 10 сард 234 буюу 50.2 хувь нь мэддэг гэжээ. Борлуулалтын цэгийн байршлыг тогтоохдоо иргэдийн дийлэнхийн саналыг аваагүй байна. Тодруулбал, 8 сарын асуулгаар 410 иргэн буюу 85.4 хувь нь, 10 сард 453 буюу 97.2 хувь нь санал аваагүй гэж хариулсан байна.

3 Эдгээрээс дүгнэхэд СШТ-ийг мэддэггүй иргэд багасч, хэрэглээг сайнаар үнэлж байгаа нь УБ хотын утааг бууруулж, агаарын чанарыг сайжруулах бодлогыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо чухал болохыг харуулж байна. Гэхдээ 2 удаагийн асуулгад оролцсон нийт 946 иргэдээс СШТ хэрэглэж үзсэн, хэрэглэдэг гэж асуулгад хариулсан 489 иргэний 28.6 хувь нь СШТ хэрэгцээг хангахгүй байна гэж дүгнэж байгаад ОББҮХороо, УБ хотын захиргааны зүгээс анхаарч, халаалтын хэрэгцээг хангахад тулгарсан бэрхшээл, шалтгааныг тогтоож, доголдлыг арилгахад чиглэсэн ажлуудыг яаралтай зохион байгуулах шаардлагатай байна.

4 СШТБЦ-ийн байршлыг асуулгад оролцсон иргэдийн тал хүрэхгүй хувь нь мэдэж байгаа бол, борлуулах цэгийн байршлыг тогтоохдоо тэдний олонхийн санал аваагүй. Борлуултын үнийн талаар 10 сар гарчихаад байхад оршин суугчдын тал хүрэхгүй хувь нь мэддэг гэж хариулсан байгаа зэргээс үзэхэд мэдээлийн хүртээмж хангалтгүй байна.

Асуулга

Сайжруулсан шахмал түлш дулааны болон ахуйн бусад хэрэгцээг хангаж буй эсэх



8 сард иргэдийн ихэнхи нь буюу 78.1 хувь нь хэрэглэж үзээгүй, 6.3 хувь нь сайн, 9.2 хувь нь бусад түлштэй хамт хэрэглэх шаардлагатай, 6.5 хувь нь тааруу гэсэн бол 10 сард 34.1 хувь нь СШТ хэрэглээг бүрэн хангаж байгаа гэсэн бол 11.2 хувь нь хангахгүй, 17.6 хувь нь бусад түлштэй хамт хэрэглэх хэрэгтэй, 37.1 хувь нь хэрэглэж үзээгүй гэсэн хариулт тус тус өгчээ. Үүнээс үзэхэд 10 сард СШТ хэрэглэж үзсэн болон хэрэглэж байгаа нийт 293 иргэний 159 буюу 54.3 хувь нь СШТ хэрэгцээг бүрэн хангаж байна, 52 иргэн буюу 17.7 хувь нь бүрэн хангахгүй байна гэсэн бол 82 иргэн 28 хувь

нь бусад түлштэй хамт хэрэглэх нь зөв гэж хариулсан байна.

Хот, дүүрэг, хороодын удирдлага, СШТ үйлдвэрлэгч “Таван толгой түлш” ХХК-ийн зүгээс хэрэгцээг нь бүрэн хангахгүй болон хагас дутуу хангаж байгаа айл өрхүүд руу техникийн туслалцаа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа явуулах шаардлагатай. Зөв галлах, яндан зуух, пийшинг солих, засах, дулаан алдагдлыг бууруулах, эсвэл ханан пийшин, нам даралтын зууханд СШТ-ийг тохируулах гэх мэт иргэдийн сэтгэл ханамжид нөлөөлөх арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Пипл Ин Нийд байгууллагаас 2019 оны 5 дугаар сард сайжруулсан шахмал түлшийг хэрэглэж үзсэн гэр хорооллын 252 иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг тодруулахад 110 (43.7%) нь хэрэглэх

боломжтой учир үргэлжлүүлэн ашиглаж байгаа гэсэн бол 89 (35.3%) иргэн түүхий нүүрснээс ялгаагүй, 53 иргэн (21%) шахмал түлшийг дахин хэрэглэхгүй гэсэн үнэлгээг өгсөн байдаг.

“PEOPLE IN NEED”
2019 ОНЫ 5-Р САР

ШАХМАЛ ТҮЛШ ХЭРЭГЛЭЖ ҮЗСЭН ГЭР ХОРООЛЛЫН 252 ИРГЭН



“Хэдийгээр 2 өөр байгууллага галлагааны улирал дуусах болон эхлэх 2 өөр хугацаанд хийсэн боловч, судалгааны үр дүнгүүд ойролцоо байгааг дурьдах нь зүйтэй”.


Дараах асуулгуудаар 5 дүүргийн судалгаанд хамрагдсан гэр хорооллын 946 оршин суугчдын хүйтний улиралд түлшээ бэлтгэдэг, хадгалдаг арга барил, сууж буй байрны өмчлөл, төрөл, ашигладаг пийшин, зуухны төрлийн талаар мэдээлэл авсан нь асуулганд оролцож буй иргэдийн ерөнхий байдлыг илэрхийлж байгаа бөгөөд СШТ-ийг

тээвэрлэх, бөөнөөр хадгалах, борлуулах хэмжээ, зохицуулалтын шийдвэр гаргахад хувь нэмэр болно гэж тооцсон.

Цаашид иргэдийн гэр сууцыг дулааны алдагдал багатай болгох, сайжруулсан шахмал түлшийг зохистой хэрэглэх бодлого, үйл ажиллагаанд эдгээр мэдээлэл тус дэмтэй гэж үзсэн болно.


Асуулга

Түлш худалдан авдаг давтамж



Асуулгад оролцсон иргэдийн бараг тал (40 хувь буюу 379 иргэн) нь түлшийг хүйтний улирал эхлэхээс өмнө нэг мөсөн авдаг бөгөөд амьжиргааны хувьд түлшээ бөөнөөр авах бололцоотой хэсэг юм. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр СШТ-ний жилийн хэрэгцээний дор хаяж тал хувийг халаалтын улирал эхлэхээс өмнө үйлдвэрлэж борлуулахад бэлтгэсэн байх шаардлагатайг харуулж байна. Нөгөө талаасаа өдөр бүр түлш авдаг, мөнгөтэй болохоор л түлш авдаг гэж хариулсан 250 иргэн буюу 26.4 хувь байна. Мөн иргэдийн бүлгийн ярилцлагын үер борлуулагч нар оройн цагаар ажиллахгүй байгаа талаар иргэдийн гомдол их байгааг

онцолж байсан болно. Иймээс өдрийн турш ямар нэгэн ажил хийж, мөнгөтэй болсон үедээ шөнө оройн цагаар түлэх түлшээ авдаг айл өрх нилээдгүй байгаа учир жижиглэнгийн цэгийн борлуулагч нарын ажлын цагийг уртасгаж ажиллуулахаас гадна борлуулагч нарын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай. Пипл ин нийд байгууллагаас 5 дугаар сард гэр хорооллын 907 иргэдийн дунд түлш хэмнэх аргуудын талаар авсан асуулгад 62.8 хувь (592 иргэн) нь хэрэглэх түлшээ портер машинаар нэг мөсөн авдаг гэсэн судалгааны үр дүн гарсан байгаа нь бидний дүгнэлттэй адил байна.




Нэг талдаа СШТ-ээ бөөнөөр бэлтгэж авах нь зардал, цаг хугацаа хэмнэх давуу талтай. Нөгөө талдаа СШТ борлуулах цэгүүдэд бөөнөөр худалдан авах боломжийг бий болгож, галлагааны улирлын эхэнд эдгээр цэгүүдэд СШТ-ний хангалттай нөөцтэй байх

зохицуулалт шаардлагатай байна. Мөн СШТ-ийг бөөнөөр авсан тохиолдолд хямд үнээр борлуулах зэрэг зах зээлийн зорицуулалтыг хийх нь иргэдийг өвлийн бэлтгэлээ эртхэнээс хангах, тэдний айдас бухимдлыг багасгахад чиглэсэн хөшүүрэг болохоор байна.

Асуулга

СШТ-ийг хадгалах байр савны нөхцөл




Асуулгад оролцогчдын 451 иргэн буюу 48 хувь нь өвлийн түлшээ хадгалах байнгын байртай байна. Мөн хэдийгээр сав байгаа боловч хэмжээ багатай 185 өрх буюу 20 хувь, 192 өрх буюу 20.2 хувь нь түлш хадгалах савгүй, гаднаа хадгалдаг, 112 өрх буюу 11.8 хувь нь шууд түлшээ хэрэглэдэг болох нь шинээр хэрэглээнд нэвтрүүлж буй

сайжруулсан шахмал түлшний нягтаршил хадгалалтыг даахаар чанартай үйлдвэрлэхэд анхаарах, чанарыг муутгахгүйн тулд хадгалалтын горимын шаардлагыг шахмал түлшний уутан дээр тодорхой бичдэг болох нь СШТ-ний хадгалалтыг сайжруулах, чанарыг хэвээр байлгахад нэмэртэй.

Асуулга

Асуулгад оролцогчдын амьдарч буй хаяг дээрх хашаа, байшингийн өмчлөлийн хэлбэр, сууцны төрөл - 946 иргэн




Гэр хорооллын 5 дүүргийн 36 хороодын 946 иргэдийн дийлэнх буюу 74.8 хувь нь хашаа байшингаа өмчилсөн эсвэл эзэмшдэг (63.8 хувь буюу 603 айл өрх хашаа, сууцаа өмчилсөн, 11 хувь буюу 105 өрх эзэмшдэг) нь

хашаа байшиндаа байнга амьдрах боломжтой байна. Харин түр суурьшсан, түрээслэсэн, эсвэл хамаатны хашаанд байгаа нь нийт асуулганд оролцогчдын 20.2 хувь болж байна

Асуулга

Амьдрах гэр сууцны төрөл



Судалгаанд хамрагдагсдын 479 өрх буюу 50.6 хувь нь өөрсдийн барьсан байшинд, 328 өрх буюу 34.7 хувь гэрт амьдардагаас үзэхэд агаарын бохирдлыг бууруулах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд (өөрийн сууцны дулаан алдагдлыг багасгах, галлагааны

хэрэгслийнхээ үр ашгийг сайжруулж, түлшээ, эрчим хүчээ хэмнэх зэргээр) өөрийн хувь нэмрийг оруулах боломж харагдаж байна. Үлдсэн 28 буюу 14.7 хувь нь түрээсийн болон бусад сууцны төрөлд амьдардаг гэж хариулсан нь байна.

Асуулга

Ашигладаг зуух пийшингийн төрөл-946 иргэн



Галлагааны хэрэгсэлд зонхилж буй төслийн хэмээн нэрлэгддэг шаталт сайтай зуух 362 өрх буюу 38.3 хувь, ердийн гэрийн зуух 178 өрх, буюу 18.8 хувийг эзэлж байна. Ханан пийшинтэй болон нам даралтын зуухтай айл 271 өрх буюу 28.6 хувь эзэлж байгаа нь сайжруулсан шахмал түлш нам даралтын зуух болон ханан пийшинд хэрхэн зохицох,

томоохон барилгыг халааж чадах эсэх асуулт гарч байгаа тул шахмал түлш үйлдвэрлэгчид сайжруулсан түлшийг ийм төрлийн галлагааны хэрэгсэлд хэрхэн тохируулах, хэрхэн зөв ашиглах талаар ард иргэдэд тайлбарлан таниулах, сурталчилгаа, сургалт хийх шаардлагатай.

Асуулга

Хүйтний улиралд түлдэг түлшний төрөл



Түлшний төрлийн хувьд дийлэнх нь буюу 54.5 хувь нь уламжлалт нүүрс хэрэглэж ирсэн бөгөөд бага зэрэг мод 13.6 хувь нь хэрэглэдэг, 31.4 хувь нь шахмал түлш ашигладаг гэжээ. Хэрэв СШТ-ний чанарыг

алдагдуулахгүйгээр зөв ашиглан, түүхий нүүрсийг орлуулбал, агаарын бохирдлыг бууруулахад ихээхэн хувь нэмэр оруулах боломжтой гэдэг нь тодорхой байна.

АЖ АХУЙ НЭГЖҮҮДЭЭС АВСАН АСУУЛГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ



Гэр хорооллын 5 дүүргийн 36 хороодын нутаг дэвсгэрт нүүрсээр галладаг байранд үйл ажиллагаа явуулдаг 36 жижиг, дунд бизнес

эрхлэгчид, үйлдвэрлэл үйлчилгээний ААН-үүдээс 5 төрлийн асуулга мэдээллийг авлаа.



Ерөнхий мэдээлэл


- 1 ААН-ийн нэр, хаяг
- 2 Үйл ажиллагааны чиглэл
- 3 Түлшний хэрэглээ, хэмжээ
- 4 Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай Засгийн Газрын 62-р тогтоолыг хэрэгжүүлэх талаар авч буй арга хэмжээ
- 5 Сайжруулсан шахмал түлшний олдоц, хэрхэн ашиглах, нөөцлөх
- 6 Сайжруулсан шахмал түлш хэрэглээнд тулгамдсан асуудал, бэрхшээл
- 7 Сайжруулсан шахмал түлш хэрэглэдэггүй, эсхүл бага хэмжээгээр хэрэглэдэг бол түүний шалтгаан
- 8 Цаашид түлшний төрөл, хэрэглээний талаар сайжруулах нэмэлт санал хүсэлт

Дээрх 8 асуулгын дагуу эдгээр ААН-үүдийн ажилтнуудтай нүүр тулж ярилцан мэдээллийг цуглуулан, санал хүсэлтийг нь авсан.

ААН-үүдийн үйл ажиллагааны чиглэл

Үйл ажиллагааны чиглэлээс харахад 36 ААН-ийн дийлэнх нь 86 хувь буюу 31 ААН нь хүнс барааны жижиглэн худалдаа эрхэлдэг, 3 нь халуун ус, цэцэрлэг, нэжгээд баар байна.

ААН-үүдийн бизнесийн төрлүүд



- 1 Баар
- 3 Халуун ус
- 1 Цэцэрлэг
- 31 Хүнсний, барааны дэлгүүр, супермаркетууд

ТҮЛШНИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ БАГЦААЛСАН ХЭМЖЭЭ

Хүйтний улиралд хэрэглэдэг нүүрсний хэмжээ




мэдээлэл
өгөөгүй

Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай Засгийн Газрын 62-р тогтоолыг хэрэгжүүлэх талаар авч буй арга хэмжээ

ТОГТООЛЫН ТАЛААР
СОНССОН



ХАЛААЛТАА ХЭРХЭН ШИЙДЭХ ТАЛ ДЭЭР
(10 САРЫН БАЙДЛААР)



ТОГТООЛЫН
ТАЛААР ОГТ
МЭДЭХГҮЙ



Хэрхэн шийдэхээ мэдэхгүй **6 ААН**


Цахилгааны үнийг бууруулах хүсэлтэй

Нам даралтын зуух СШТ зохицох эсэх

Түүхий нүүрс хэрэглэсний арга хэмжээ

Тогтоолыг биелүүлэх эрмэлзэлтэй **10 ААН**

Төрийн шаардлагад тохируулан хэрэглээгээ шийдэж чадаагүй Хүйтний улирал ирэхэд түүхий нүүрс хэрэглэх магадлал өндөртэй.



Сайжруулсан шахмал түлшний олдоц, хэрхэн ашиглах, нөөцлөх тухай

20 ААН шахмал түлшний олдоц ямар байгаа мэдээлэл байхгүй, хэрхэн ашиглахыг ч мэдэхгүй байна.

Харин 10 ААН шахмал түлш олдохгүй байгаа, бөөний борлуулах цэг байхгүйд санаа зовж байгаагаа илэрхийлж байв.

Зарим ААН граждаа СШТ хадгалахаар төлөвлөсөн. Одоогоор ААН-д худалдан авч нөөцөлсөн ШТ байхгүй, мөн нөөцлөх савгүй, хаанаас авахаа мэдэхгүй, мэдээлэл дутмаг байна.

Үүнээс үзэхэд ААН-үүд хүйтний улирал ойрхон байхад СШТ олж авах, нөөцлөх, хэрэглэх талаар ямар ч бэлтгэлгүй бөгөөд халаалтын улирал эхлэхэд СШТ хэрэглэхэд бэлэн бус байна.

Сайжруулсан шахмал түлшийг хэрэглэхэд тулгамдсан асуудал, бэрхшээл



Аль ч ААН шахмал түлшийг хэрэглэж, туршиж үзээгүй

СШТ-ний олдоц, бөөний болон жижиглэн худалдаалах цэгүүдийн талаар мэдээлэлгүй



Шахмал түлшний талаар ямар нэгэн мэдээлэл байхгүй

Хэдий зарим нь хайсан ч борлуулалт хийж буй цэг байхгүй



Сайжруулсан шахмал түлш хэрэглэдэггүй, эсхүл бага хэмжээгээр хэрэглэдэг бол түүний шалтгаан

Шахмал түлшийг худалдаж авах боломж бага, хэрэглэж үзээгүй учир мэдээлэл багатай

Том оврын нам даралтын зууханд шахмал түлшийг хэрэглэж болох эсэх талаар мэдэхгүй

Нам даралтын зууханд СШТ зохицох эсэх талаар зааварчилгаа гаргаж түгээх талаар хүсэлт тавьж байв.

Цаашид түлшний төрөл, хэрэглээний талаар сайжруулах нэмэлт санал хүсэлт



СШТ-ний бүх мэдээллийг хүртээмжтэй болгох



Үнийг хямд байлгах



Түлшээр тасралтгүй хангах



Бөөний цэг байгуулах



Борлуулалтын цэгийг олшруулах




Нам даралтын зууханд СШТ-ийг хэрэглэх заавар боловсруулж түгээх

Гэр хороололд байршилтай худалдаа үйлчилгээ эрхэлдэг нам даралтын зуухтай ААН-үүдэд СШТ хэрэглүүлэх, борлуулах

талаар мэдээлэл, зааварчилгаа өгөх хүргүүлэх зохицуулалтын ажлууд маш дутагдалтай байна.

СШТ БОРЛУУЛАГЧДААС АВСАН АСУУЛГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ



Сайжруулсан шахмал түлш борлуулагч болон борлуулах хүсэлтэй 33 хүнтэй мониторингийн баг уулзаж дараах төрлийн асуулгын дагуу мэдээллийг цуглуулжээ.



Мэдээлэл

- 1 Сайжруулсан шахмал түлшний гэрээтэй эсэх
- 2 Сайжруулсан шахмал түлш хадгалах, борлуулах байр савтай эсэх
- 3 Байртай бол, хэмжээ (тонн) үгүй бол СШТ-ийг зохистой хадгалах байр савны талаарх авах арга хэмжээ юу болох ?
- 4 СШТ-ыг хадгалах нөхцөл, шаардлагын талаар мэдээлэлтэй эсэх
- 5 Түлш борлуулах хороо, хэсэг ба түлш авдаг өрхийн тоо
- 6 Одоогийн нөөцийн хэмжээ, тонноор /эрэлт нийлүүлэлтийн байдал
- 7 Шаардлагатай нөөц хэд болох, СШТ-ийг бөөний цэгт тээвэрлэж буй зохицуулалт оновчтой эсэх
- 8 Сайжруулсан шахмал түлшний олдоц ямар байгаа? Хэд хоногт нийлүүлдэг болон давтамж?
- 9 Сайжруулсан шахмал түлшний тээвэрлэлтийн талаарх санал
- 10 Сайжруулсан шахмал түлшний хэрэглээний талаар зохицуулалтыг сайжруулах санал
- 11 Сайжруулсан шахмал түлшний хүртээмжийг сайжруулах санал
- 12 Сайжруулсан шахмал түлшний хадгалалт, хэрэглээг сайжруулах санал
- 13 Сайжруулсан шахмал түлшний борлуулалтыг сайжруулах санал
- 14 Бусад санал хүсэлт



САЙЖРУУЛСАН ШАХМАЛ ТҮЛШНИЙ ГЭРЭЭТЭЙ ЭСЭХ

10 сарын 15-ны байдлаар 33 СШТ борлуулагчдаас 3 нь ярилцлага авах үед Тавантолгойн ШТ үйлдвэртэй албан ёсны гэрээ байгуулсан, бусад нь гэрээгээ байгуулах гэж байгаа эсвэл борлуулах хүсэлтэй байлаа.

Галлагааны улирал эхэлсэн энэ үед борлуулах гэрээ байгуулах үе шат хэт удаашралтай байна. Гэрээг олон борлуулагчтай яаралтай байгуулах нь нэн шаардлагатай байна.



Сайжруулсан шахмал түлш хадгалах, борлуулах байр савтай эсэх, байртай бол, хэмжээ (тонн) үгүй бол СШТ-ийг зохистой хадгалах байр савны талаарх авах арга хэмжээ юу болох ?



Борлуулалтанд ажиллах хүсэлтэй иргэдийн ихэнхи нь контейнер, граж, агуулах зэрэг СШТ хадгалах байр савтай байгаа гэж хариулжээ.

Зарим нь нэмж хадгалах байр сав авахаар төлөвлөж байгаа.



СШТ-ЫГ ХАДГАЛАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН ТАЛААР МЭДЭЭЛЭЛТЭЙ ЭСЭХ



Асуулгад оролцогсдын 60 хувь нь СШТ-ыг хадгалах нөхцөл, горим, шаардлагын талаар мэдээлэлтэй



Гэрээ байгуулсан хүнийг Тавантолгойн СШТ үйлдвэр сургалтанд хамруулсан



Цаашид олон борлуулагчтай гэрээг байгуулж сургалтанд яаралтай хамруулах шаардлагатай.



Түлш борлуулах хороо, хэсэг ба түлш авдаг өрхийн тоо

Түлш авах өрхийн тоог 50-400 гэж таамаглаж байв. СШТ-ийг худалдан авагчдын тооны талаар асуулгад оролцогсод нэгдсэн мэдээлэлгүй.

Хаана ямар хороо, хэсэгт зарах талаар зохицуулалтгүй. Яаралтай хуваарилалтыг хийх шаардлагатай.



САЙЖРУУЛСАН ШАХМАЛ ТҮЛШНИЙ ОЛДОЦ ЯМАР БАЙГАА? Хэд хоногтоо нийлүүлдэг болон давтамж?

Одоогийн байдлаар олдоц ховор, захиалгаар нийлүүлдэг хэдий ч зарим үед 2 хоногоор нийлүүлэлт тасардаг.

Одоогийн нөөцийн хэмжээ, тонноор /ЭРЭЛТ НИЙЛҮҮЛЭЛТИЙН БАЙДАЛ

10-25 тн зөөвөрлөдөг, хурдан дуусдаг, эрэлт ихтэй, иргэд их асууж сураглаж байна.

СШТ-ний үйлдвэрт дуулгасан боловч нийлүүлэлт хийгээгүй.

3 тонны нөөцтэй.

Зарим нь 10, 25 кг-аар борлуулах саналтай.

Үйлдвэрээс нийлүүлэлт эхлээгүй гэсэн хариулт өгсөн.

Нийлүүлэлт хангалтгүй байна, хугацаа мөн оройтож байна.

Шаардлагатай нөөц хэд болох, СШТ-ийг бөөний цэгт тээвэрлэж буй зохицуулалт оновчтой эсэх

Тодорхой тогтоосон нөөцийн тоо, мэдээлэл байхгүй

3-7 хоногт нийлүүлдэг.

Задгай нийлүүлж, газар дээр нь шуудайлдаг.

Хүрэлцээ муу.

Сайжруулсан шахмал түлшний талаар иргэдийн мэдээлэл ямар байгаа? Ямар асуултыг голдуу нийтлэг асууж лавладаг вэ?

Иргэд маш ихээр асууж ирж байна. Зарим нь СШТ-ний талаар авч буй одоогийн зохицуулалтанд итгэл муутай хандаж байна. *

Ямар төрлийн зууханд яаж таарах талаар их асууж байна. *

Шуудайлсан СШТ их үйрч нунтаг болсон байгаа учир, үйлдвэрлэх болон тээвэрлэх явцад чанар нягтшилд их анхаарах шаардлагатай байна. *

Зарим иргэд угаартахаас айж, бага хэрэглэдэг. *

Дөрвөлжин хэлбэртэй учир СШТ асахдаа тааруухан. *

СШТ-ний хэрэглээний тал дээр иргэдийн 50% нь сайн, хагас нь муу гэдэг. *

Утаа нүдэнд харагдахгүй хэдий ч хоолой боож, ам хатдаг. *



ДУГНЭЛТ

Иргэд, ААН, борлуулагч нарын дунд явуулсан ажиглалтын мэдээлэлд үндэслэн дараах асуулга, ярилцлага, мониторингийн багийн дүгнэлт гарч байна.



ИРГЭДИЙН АСУУЛГЫН ХАРИУЛТЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ



Төрөөс УБ хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлж буй түүхий нүүрсийг хориглох, сайжруулсан шахмал түлшийг нэвтрүүлэх шийдвэр хэдийгээр зөв зүйтэй боловч, цаг хугацаа хэт давчуу, СШТ-ын үйлдвэрлэлийн хэмжээ бага, түгээлт хангалгүй байна.



Ард иргэд нэгэнт түүхий нүүрс борлуулахыг хориглосон, хүйтэн сэрүүний улирал дөхөх тусам СШТ-ний олдоц ховор байгаад их санаа зовж байгаа нь тэдний өгсөн хариулт, санал хүсэлтээс тодорхой байна.



Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох Засгийн газрын тогтоолын талаар иргэдийн дийлэнх (71- 80%) нь зохих мэдлэгтэй байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хороо, хэсгээс өгч буй мэдээлэл иргэдэд хүртээмжтэй байв. Төрөөс дээрх 62 дугаар тогтоолыг олон нийтэд тайлбарлан таниулах талаар зохион байгуулсан ажил иргэдэд харьцангуй тааруухан хүрчээ. Тухайлбал, 8 сарын байдлаар ярилцлагад хамрагдсан иргэдийн 41.7 хувь, 10 сарын байдлаар 42.5 хувь нь мэдээлэл авсан байна.



Уламжлалт түүхий нүүрсийг орлуулах СШТ-ний талаар иргэдийн мэдлэг, ойлголт 8 сарын байдлаар тааруухан буюу 480 иргэний 68.7 хувь (330) энэ талаар мэдэхгүй байв. Харин 10 сард СШТ-ийг мэддэггүй иргэн 27.3 хувь (127) болж багасчээ.



Мөн СШТ борлуулах цэгийн тухай эдгээрийн байршилын талаар иргэдээс санал авах асуудлууд 8 сард 37.1 хувь нь мэддэг буюу бага хүрсэн бол 10 сард сайжирч 195 иргэн буюу 41.8 хувь нь мэддэг болсон байна. Хэдийгээр мэдээллийн хүртээмжийн талаар дүгнэлт ийм байгаа ч СШТ борлуулах үнийн талаар 50 хувь нь мэдэж байв. Үүнээс үзэхэд иргэд сонирхсон зүйлээ ямар нэгэн аргаар мэдэж чаддаг, сохирхоогүй буюу эрх ашиг нь хөндөгдөөгүй бол анхаарлаа хандуулдаггүй, чихнийхээ хажуугаар өнгөрөөдөг гэж үзэхээр байна. Иймээс мэдээлэл сурталчилгааг хэвшмэл бус өвөрмөц байдлаар зохион байгуулах нь мэдээллийн хүртээмжийг сайжруулах ач холбогдолтой.

СШТ хэрэглэсэн иргэдийн сэтгэл ханамжийн байдал:

Иргэд тоо	2019 оны 8 сар	Иргэд тоо	2019 оны 10 сар
375	86%	159	54.3%
44	9.1%	52	17.7%
31	7.1%	82	28%
30	6.9%		

Хомс мэдлэгтэй | Бүрэн хангаж байна
Өөр түлштэй хамт хэрэглэх шаардлагатай | Бүрэн хангахгүй
Тааруухан | Бусад түлштэй хамт хэрэглэх шаардлагатай
Сайн | /СШТ хэрэглэгч 293 иргэдийн/

50%

Асуулгад оролцогсодын тал хувь нь түлшээ хүйтний улирал эхлэхээс өмнө бөөнөөр нь бэлтгэдэг, хангалттай байр савтай байдаг учир өвлийн бэлтгэл хийдэг 8-10 саруудад СШТ олдоц ховор байгаа нь иргэдийн бухимдлыг бий болгож байгаа нь ажиглагдлаа.

29%

Мөн асуулгад оролцогсодын 29 хувь нь нам даралтын зуух, ханан пийшин ашигладаг бөгөөд СШТ ийм төрлийн зуух пийшинд тохирсон эсэх, СШТ-ийг ийм зуухад хэрхэн хэрэглэх талаар зааварчилгааг СШТ үйлдвэрлэгч яаралтай боловсруулан түгээх шаардлага гарч байна.



Иргэд болон өөрийн халаалттай ААН-д ойлгомжтой танилцуулга, мэдээллийг олон сувгаар зэрэг, тогтмол давтамжтай хүргэх шаардлагатай байна. Шинэ түлш санал болгож буй учир түүний ач холбогдол, үнэ, борлуулах цэг, дулаан хадгалах байдал хэрэгцээг нь хангаж чадах эсэх талаарх мэдээллийг цаашид өргөжүүлж, хүртээмжтэй түгээх арга хэмжээ авах нь төрөөс хийх эхний үйл ажиллагаа байх ёстой байна.



ААН-ҮҮДИЙН АСУУЛГЫН ХАРИУЛТЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Гэр хороололд худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААН-үүдийн дунд явуулсан асуулгын хариултаас үзэхэд, агаарын томоохон бохирдуулагчдын хувьд эдгээр байгууллагуудад хандсан бодлого, шийдэл орхигдсон байна. Тухайлбал, зарим ААН хүйтний улиралд 130 тонн нүүрс зарцуулдаг байна. Үүнийг дунджаар нэг өвөл 3 тонн нүүрс түлдэг айл өрхтэй харьцуулбал, 43 айлаас нүүрс түлэх үед гарах бохирдолтой тэнцэж байна.

Жижиг ААН



Айл өрх



ААН-үүдийн галлагааны зуухнуудад СШТ тохирох эсэхийг яаралтай турших боломжийг олгох, мөн тохирох бол СШТ-ийг ашиглах зааварчилгааг түгээж, СШТ-ий хангалттай нөөцийг ААН-дэд бий болгох шаардлагатай. Эс тэгвээс гэр хороололд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний газрууд хаагдах, эсвэл нүүрсээр галлах шаардлага зайлшгүй гарч байна.

ААН-үүдийг дулааны асуудлаа яаралтай төрийн агаарын бохирдолыг бууруулах талаар баримталж буй бодлогод нийцүүлэхийг төрийн байгууллагууд шаардах хэрэгтэй. Зөвхөн шаардах нь өрөөсгөл тул иргэдтэй адил мэдээллийг түгээх, тайлбарлан танилцуулж сурталчилах шаардлага байгааг дурдах нь зүйтэй.



СШТ борлуулагчдын асуулгын хариултын шинжилгээний дүгнэлт



Төрөөс авч явуулж буй 62 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний нэг зохицуулалт нь борлуулалт болж байна. 10 сарын 15-ны байдлаар СШТ-ний ихэнх борлуулагч нар гэрээ байгуулаагүй, зарим борлуулалтын бөөний болон жижиглэнгийн цэгүүдийн байршил зарим дүүрэг хороонд тодорхой бус, СШТ бөөний дундын цэгүүдэд харьцангуй олдоцтой ч жижиглэнгийн борлуулалтын цэгүүд дээр олоц ховор байгаа нь түүхий нүүрсийг халах, СШТ-ээр оруулах хүчин чармайлтыг үр дүнгүй болгох эрсдэлийг бий болгож байна.



Мөн борлуулагчдын тоо, байршлын мэдээлэл одоогоор бүрэн тодорхой болоогүй, энэ чиглэлийн ажил маш хангалтгүй байна гэж дүгнэхээр байна.



Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх анхан шатны нэгж нь болж буй борлуулагч нарт өнөөдрийг хүртэл өгсөн мэдээлэл, сургалт хангалтгүй байна



Иргэд сайжруулсан шахмал түлшний химийн найрлага, эрүүл мэндэд ямар нөлөөтэй талаар, хамгийн чухал нь угаартаж амь нас хохирох эрсдэл буй эсэхэд ихээхэн санаа зовниж байгаа бөгөөд эхний хандаж асуудаг цэг нь сайжруулсан шахмал түлш борлуулах цэг байна. Иймээс иргэд, ААН-тэй харьцах, мэдээлэл авах анхдагч эх сурвалж болохын хувьд нь тусгайлан сургалт хийж, байнгын мэдээллээр хангаж байх шаардлагатай.



Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх үүрэг бүхий анхан шатны нэгжид зохицуулалт, уялдаа холбоо, менежмент хийх шаардлагатай байна.



Үйлдвэрлэгч, СШТ, борлуулагч, дүүргийн Засаг дарга, нийслэлийн Засаг дарга зэрэг институт, нэгжүүд үйл ажиллагаагаа нэн даруй уялдуулах, зохион байгуулах шаардлагатай байна.



СШТ нь улирлын чанартай хэрэгцээний асуудал тул цаг нь тулах тусам ач холбогдол улам бүр буурч, хүйтний улирал дөхмөгц иргэд, ААН уламжлалт түүхий нүүрс хэрэглэх нь ойлгомжтой бөгөөд үүнд иргэд, ААН, СШТ-ний борлуулагчдыг буруутгах ямар ч үндэслэлгүй байна.







ЗӨВЛӨМЖ

ЗГ-ийн түүхий нүүрсийг халах, сайжруулсан шахмал түлшийг хэрэглээнд нэвтрүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх үүднээс 5 дүүргийн гэр хорооллын 36 хороодын иргэд, ААН, шахмал түлш борлуулагч нарын дунд хийсэн

мониторингийн ажлын үр дүнгийн дүгнэлтэнд үндэслэн дараах зөвлөмжийг холбогдох ажил хариуцсан байгууллагууд, сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэгч, борлуулагчид, иргэдэд өгч байна.

“Тавантолгой түлш” сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх компанид

Мониторингийн дүнгээс үзэхэд, шахмал түлшний олдоц 10 сарын 20-ны байдлаар “Таван толгой түлш” ХХК-ийн СШТ-ний үйлдвэрийн хүчин чадлаас хамааран бага байгаа нь иргэдийн бухимдлыг бий болгож, нөгөө талаар түүхий нүүрс борлуулагчид энэ нөхцлийг ашиглаж СШТ-ний талаар таагүй яриа гаргаж буй тохиолдлууд байна. Иймээс дараах ажлуудыг оновчтой зөв зохион байгуулах шаардлагатай байна. Үүнд:

	СШТ үйлдвэрлэлийн хүчин чадал, ажиллах хүчийг нэмэгдүүлэх		СШТ-ний чанарыг сайруулах, түүхий нүүрсийг ялан гарах
	Оновчтой зохион байгуулалт шаардлагатай		Түгээх, тээвэрлэх, борлуулах тогтолцоог 2-3 дахин нэмэгдүүлэх

Иргэдийн дунд хийсэн хөндлөнгийн мониторингийн үр дүнг үзэхэд СШТ-ний нийлүүлэлт жижиглэн борлуулалтын төвшинд маш дутагдалтайн улмаас тооны хязгаартай өгч байгаа нь өвөл эхлэхээс өмнө түлшээ нөөцөлж хэвшсэн ихэнх иргэдийн дунд бухимдлыг бий болгож байна. Ялангуяа, жижиглэн цэгийг яаралтай нэмж байгуулах, эрэлт хэрэгцээг хангах ажлыг эрчимжүүлэх ажил хамгийн чухал. Үүний тулд:



Бөөний болон жижиглэнгийн борлуулагчдын тоог өмнөх жилүүдэд гэр хорооллын гудамжинд нүүрс борлуулагчдын тоо хэмжээтэй адил байхаар нэмэгдүүлэн гэрээ байгуулан ажиллуулах замаар зах зээл дээрх СШТ-ний олдоц, хүртээмжийг сайжруулах



СШТ-ийг зөв тээвэрлэх, хадгалах, ард иргэдэд ашиглах зөвлөгөө, зааварчилгааг өгүүлэх чиглэлээр борлуулагчдыг сургаж, байр савыг бэлтгүүлэх



СШТ-ний үйлдвэрээс бөөний цэгүүдэд СШТ-ийг тасралтгүй тээвэрлэх тогтолцоог бүрдүүлж, хувийн хэвшлийг татан оролцуулах, нөөцийн талаар мэдээллийг борлуулагч нарт тогтмол өгөх



Борлуулагчтай гэрээ хийхдээ 2 сая төгрөгийн урьдчилгаа-/барьцаа/ авдаг зохицуулалт нь борлуулагч болох хүсэлтэй олон иргэдэд гол саад болж байна. Зөвхөн бэлэн мөнгөөр бус үл хөдлөх хөрөнгө, хашаа гэр, сууц, эсвэл бусадарга хэрэгслийг ашиглах боломжийг шуурхай судалж, борлуулагчдын тоог яаралтай нэмэгдүүлэх шийдвэр гаргах



Борлуулалтын хэмжээгээр борлуулагч нарыг нэмж урамшуулдаг тогтолцоог бий болгох



Найдвартай борлуулагч байхгүй тохиолдолд хүнсний жижиг дэлгүүртэй гэрээ байгуулан СШТ худалдаалах нэмэлт цэгүүдийг бий болгох



Үйлдвэрээс санаачлан хөдөлгөөнт борлуулалтын цэгүүд ажиллуулахаар төлөвлөж байгаа нь өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангахад бодитой хувь нэмэр болох учир үйлчилгээг цаг алдалгүй яаралтай эхлүүлэх



СШТ хэрэглэж буй нийт иргэдээс 83 буюу 28.3 хувь нь нэвтрүүлж буй шахмал түлш хэрэгцээг бүрэн хангахгүй байгаа гэсэн хариулт өгсөн. Мөн түүнчлэн асуулгад оролцсон иргэдийн 21.9 хувь нь сэтгэл ханамж дунд гэсэн үнэлгээ өгсөн. Үүний шалтгааныг тогтоож, хэрэглээг бий болгох нь үндэслэл муутай, яриа цуурхалыг бууруулах, СШТ-ийг өргөнөөр ашигладаг болгоход маш чухал асуудал юм. Үүний тулд дараах асуудлуудыг шийдэх хэрэгтэй гэж зөвлөж байна. Үүнд:



Гэрээт борлуулагч нараар СШТ худалдан авагч нартай санал хүсэлтийн дэвтэр ажиллуулах замаар эргэх холбоог бий болгож, СШТ-ний хэрэглээ яагаад муу байгаа талаар санал хүсэлтийг хүлээн авч, хаягийн дагуу зуух халаалтын хэрэгсэл (пийшин, зуух, яндангийн нөхцөл байдал, хийц, галлагааны арга барил, хадгалалт, гэр, орон сууцны дулаалга, дулааны алдагдал зэрэг)-д мэргэжлийн дүгнэлт гаргах чадавхитай баг ажиллуулж, шалтгааныг нарийвчлан тодруулах. Одоогоор тус үйлдвэрээс ажиллуулж байгаа Засвар үйлчилгээний Төвийн хүний нөөцөд түшиглэн мэргэжлийн багуудыг байгуулах.

Мэргэжлийн баг, эсвэл багуудын тайланд үндэслэн түгээмэл шалтгаануудыг (Зөв галлах, яндан зуух, пийшинг солих, засах, дулаан алдагдлыг бууруулах, эсвэл ханан пийшин, нам даралтын зууханд СШТ-ийг тохируулах гэх мэт) тогтоож, айл өрхийн төвшинд хэрэгжүүлэх боломжит шийдлүүдийг тодорхойлох, борлуулагчид болон бусад мэдээллийн хэрэгслийг ашиглан иргэдэд түгээн дэлгэрүүлэх.



Мэргэжлийн багт ажиллах халаалтын, барилгын хийц, дулааны алдагдлыг бууруулах мэргэжилтнүүдийг татан оролцуулах талаар Засгийн газрын агентлагууд, хот дүүргийн захиргаатай хамтран ажиллаж шийдвэрлэх.

Янз бүрийн зуух, пийшин, ялангуяа нам даралтын зуухнууд, ханан пийшингүүдэд СШТ-ийг тохируулан хэрэглэх боломжийн судалгааг, мэргэжлийн судлаачид, лабораториудтай хамтран яаралтай хийж, турших, туршилтын үр дүнд тулгуурлан түлшийг хэрэглэх гарын авлага боловсруулах, сургалт сурталчилгааг зохион байгуулах.



СШТ-ний одоогийн хэлбэр нь шатах гадаргуугийн хэмжээ багаас шалтгаалан шаталт явагдах хүртэл илүү их энерги шаарддаг, үүнээс үүдэн угаарын хий ялгарах, угаартах магадлал их гэсэн шүүмжлэл хэлэлцүүлгийн үеэр их гарсан тул дундаа нэг том нүх, эсвэл олон жижиг нүх үүсгэн шатах гадаргууг ихэсгэн эдийн засгийн, агаар орчинд, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг үндэслэн үйлдвэрлэх боломжийг судлах.

УБ хотын ЗАА, ЗДТГ болон дүүргүүдийн ЗДТГ-т



СШТ-ний хэрэглээ яагаад муу байгаа талаар санал хүсэлтийг хүлээн авах



Мэргэжлийн холбоод, хотын захиргааны харьяа агентлагуудын холбогдох мэргэжилтнүүдийг татан оролцуулж мэргэжлийн баг үүсгэх



Айл өрхөд СШТ зөв хэрэглэхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг бий болгох



Тавантолгойн түлш компанийн засвар үйлчилгээний ажилд дэмжлэг үзүүлэх.

Мэргэжлийн баг, эсвэл багуудын тайланд үндэслэн түгээмэл шалтгаануудыг тогтоож, айл өрхийн төвшинд хэрэгжүүлэх боломжит шийдлүүдийг тодорхойлох.



Зөв галлах



Дулаан алдагдлыг бууруулах




Яндан зуух, пийшинг солих, засах



Ханан пийшин, нам даралтын зууханд СШТ-г тохируулах

Сургалт, сурталчилгаа явуулах мэдээллийн эх үүсвэрийг нийтэд зарлах, тайлбарлан таниулах:

Сургалтын материал, зааварчилгааг борлуулалтын цэгүүдээр дамжуулан иргэдэд тараах:



СШТ хэрэглэх явцад дутуу шаталтаас үүсч буй угаарын хий (нүүрстөрөгчийн дутуу исэл)-д хордож, амь насаа алдах, эрүүл мэндээр хохирох явдал нилээдгүй гарсан бөгөөд цаашид ч бас тохиолдох магадлалтай. Дээр дурьдсан мэргэжлийн багийн үүрэг, оролцоо дараах зөвлөмжийг гүйцэтгэхэд чухал ач холбогдолтой байна.

Иргэдийн дунд мэдээллийн олон их сурвалжаар байнга давтамжтай сурталчилах:



СШТ-ний зөв хэрэглээ



СШТ-ний зөв хадгалалт



Галын аюулгүй байдлыг хангах талаар

Ялангуяа СШТ хэрэглэсний улмаас угаартаж нас барсан тухай мэдээлэл 10 сард гарсанаас хойш ОБЕГ, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, НЗДТГ зэрэг байгууллагаас СШТ-ийг зуух, пийшинд хэрхэн хэрэглэх, шахмал түлшний химийн найрлага болон угаартах эрсдэлийг бууруулахад чиглэсэн мэдээллийг олон нийтэд өгч эхэлсэн. Өмнө нь энэ талаарх мэдээллийг хүргэх ажил сайн хийгдээгүй бөгөөд дээрхээс сургамж авч цаашид энгийн, ойлгомжтой хэлбэрээр анхааруулах мэдээллийг иргэдэд тодорхой давтамжтайгаар байнга түгээх зайлшгүй шаардлагатай.

Янз бүрийн зуух, пийшин, ялангуяа нам даралтын зуухнууд, ханан пийшингүүдэд СШТ-ийг тохируулан хэрэглэх талаарх судалгааг мэргэжлийн судлаачид, лабораториудын оролцоотойгоор хийх



Тэдэнд зориулсан сургалт явуулах



Сурталчилгааг сонирхол татсан өвөрмөц аргаар зохион байгуулах



Үйлдвэрлэгч, СШТ борлуулагч, дүүргийн Засаг дарга, нийслэлийн Засаг дарга зэрэг институт, нэгжүүд үйл ажиллагаагаа нэн даруй уялдуулан зохион байгуулах



Үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах талаар Үндэсний хорооноос чиглүүлэх, үр дүнг тооцох ажлыг хариуцах



Төрийн байгууллагуудын зүгээс Таван толгой түлш компаниас жижиглэн борлуулагчдыг нэмэгдүүлэхэд тулгарч буй бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх арга зам, дэмжлэг туслалцааг нэн яаралтай үзүүлэх шаардлагатай байна.



Шинэ бүтээгдэхүүний нийлүүлэлтийн одоогийн нөхцөл байдалд оновчтой, зөв маркетинг, хүч хөрөнгө юунаас илүү чухал шаардагдаж байгааг төрийн байгууллагууд маш сайн ойлгож, ажиллах шаардлагатай.



Мониторинг

Түүхий нүүрсний хэрэглээнд хяналт тавихаар цагдаагийн байгууллагаас зохион байгуулагдсан шинэ бүтцийн ажлын үр дүнд мониторинг хийх



Дүгнэлт

Гүйцэтгэлийг тогтмол дүгнэх



Оролцоо

Гүйцэтгэлийг дүгнэхийн тулд идэвхитэй ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах

Эрчим хүчний зохицуулах хороонд

Агаарын бохирдолтой тэмцэх ажлын хүрээнд гэр хорооллын айлуудыг шөнийн хугацаанд эрчим хүчний хөнгөлөлтөд хамруулж буй үед цахилгааны хэт ачааллаас үүдэлтэй цахилгаанаар халаалтын асуудлаа шийдвэрлэсэн айл өрхүүдийн эрх ашиг зөрчигдөх тохиолдол гарч байгаа тухай мониторингийн үр дүнгийн хэлэлцүүлгийн үеэр нилээд гарсан тул дараах ажлуудыг зохион байгуулах шаардлагатай.

Урьдчилан сэргийлэх:

Пускатель, щитэнд эвдрэл гарах

Утас гэмтэх шатах

Халаалтын хэрэгслээс үүдсэн гал түймэр гарах

Гэр хорооллын айл өрхүүдэд:

Урьдчилан сэргийлэх үзлэг хийх

Техникийн туслалцаа, зөвлөгөө өгөх

Мэргэжлийн багуудыг зохион явуулах



Мөн шөнийн халаалалтанд хөнгөлөлт үзүүлэхтэй холбоотойгоор гадаад орнуудаас янз бүрийн хүчин чадлын, эрчим хүч хэмнэдэг, эс хэмнэдэг цахилгаан халаалтын хэрэгслийг арилжааны зориулалтаар авчирч сурталчлах явдал ихэссэн тул зах зээл дээрх халаалтын төрөл бүрийн хэрэгсэлд хурдавчилсан үнэлгээ хийх замаар иргэдэд зөв бодитой мэдээллийг хүргэж, зөв сонголт хийхэд нь туслалцаа дэмжлэг үзүүлэх ажлыг цаг алдалгүй зохион байгуулах.



Цахилгааны хэрэглээтэй холбоотой ослын янз бүрийн дуудлагад цаг алдалгүй очиж туслалцаа үзүүлэх зохицуулалтыг хийх.



ААН-үүдийн галлагаатай байруудыг цахилгаанд холбох, СШТ-ийг нам даралтын зууханд ашигладаг болгоход яаралтай дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах.



Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газар, дүүргүүдийн Мэргэжлийн Хяналтын хэлтэст

Гэр хорооллын гэрийн халаалтанд төслийн зуухыг ашиглах, гар хийцийн бусад зуухыг ашиглахыг хориглосон Нийслэлийн засаг даргын 2017 оны 4 дүгээр сард гарч, 2018 оны 2 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн шийдвэрийн:



Биелэлтэнд хяналт тавих

Хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах



Дүүрэг хороодын ЗД-ын ажлын албадад энэ талаар дэмжлэг үзүүлэх



11,12 сар



Барилгын, эрчим хүчний мэргэжлийн хяналтын байцаагчдын багуудыг СШТ-тэй холбоотой асуудлыг хурдан шийдвэрлэх зорилгоор гэр хорооллын айлуудыг СШТ-ээр зөв галлагаа хийж хэвштэл 11-12 дугаар саруудад үргэлжлүүлэн ажиллуулах ажлыг зохион байгуулах

Гэр хорооллын хороодын засаг даргын ажлын албанд



Хорооны нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээ эрхэлдэг бөгөөд СШТ хэрэглэдэг ААН-үүдийг хүсэлтэнд үндэслэн түлшний карт олгох ажлыг яаралтай зохион байгуулах



ААН-дийн төрийн бодлогод нийцүүлэн халаалтаа хэрхэн шийдэж байгаа, нөхцөл байдлаас шалтгаалан хэрэглэж болзошгүй байгаа тул түүхий нүүрсний хэрэглээнд нь хяналт тавих



Сайжруулсан гэрийн зуух (Төслийн гэж нэрлэгддэг)-ны эвдрэл гэмтэл, засвар үйлчилгээнд хэрэглэх запас болон үйлчилгээ хийх хэрэгцээ шаардлагын тухай мэдээллийг хэсгийн ахлагч нараар дамжуулан цуглуулах, мөн засвар үйлчилгээний сайн туршлага, сайн санаачлагыг бүртгэн авч бусад хороод, "Таван толгой түлш" компанийн засвар үйлчилгээний төвд борлуулагч нараар дамжуулан сурталчлах

Нийгмийн халамжийн газарт

Эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн үйл ажиллагааны хувьд дүүргүүд эмзэг буюу зорилтот бүлгийнхээ иргэдэд халамжийн үйлчилгээний хүрээнд урьдын адил түлээ нүүрсний үнийг 11 сараас эхлэн олгох арга хэмжээг авч байгаа бөгөөд тухайлбал: Хан-Уул дүүргийн хувьд зорилтот бүлгийн айл өрхүүдэд туслах зорилгоор сайн үйлсийн аян өрнүүлжээ. Дүүргийн төр, захиргаа болон хувийн хэвшлийн байгууллагуудын ажилтан, албан хаагчид "Эко дүүрэг-Утаагүй орчин" сайн үйлсийн аянд сайн дураараа нэгдэж, бөөний цэгт шахмал түлш савлаж, зорилтот бүлгийн айл өрхүүдэд хандивлаж буй сайн туршлагаудыг олон нийтэд түгээхийг иргэдийн зүгээс санал болгож байгааг анхаарах шаадлагатай

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, УБ хотын агаарын бохирдолтой тэмцэх газарт



Тавантолгой Шахмал түлшний үйлдвэр СШТ үйлдвэрлэхээс гадна бүх хэрэглэгчдэд ойртуулан түгээх, жижиглэн борлуулах ажлыг давхар хариуцах нь энэ байгууллагын албан хаагчид, ажилчдыг хэт ачаалалтай болгож байна. Үүнээс үүдэн СШТ-ний чанар, олдоц, нийлүүлэлтэнд сөрөг нөлөө гарч байна. Иймээс бүтээгдэхүүн тээвэрлэлт, борлуулалтын асуудлыг тээврийн болон худалдаа арилжааны байгууллагуудад шилжүүлж, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг нэн тэргүүнд хангах хэмжээнд үйлдвэрлэх, ханан пийшин, нам даралтын зуух зэрэг олон төрлийн зууханд хэрэглэж болохуйцаар бүтээгдэхүүнийхээ төрөл чанарт илүү анхаарч ажиллах боломж нөхцлийг бий болгох.



Эмзэг бүлгийн иргэдэд хүртээмжтэй байлгах үүднээс орлогын нотлогоог үндэслэн СШТ-ний үнийг бууруулах, хөнгөлөлтэй олгох асуудлыг Засгийн газарт уламжлан шийдвэрлүүлэх



СШТ хэрэглэж буй ААН-д татварын эсхүл ямар нэг хөнгөлөлт урамшуулал олгох асуудлыг журамлах




10 сарын 15-ны байдлаар борлуултын цэгүүдэд (Баянзүрх дүүргийн Цайз захын борлуулалтын цэг) нэг удаад зөвхөн 2 шуудай СШТ худалдаалж буй явдал нь иргэдийг бухимдуулж байна. Ялангуяа хүйтний улирал хаяанд ирсэн, Хотын гэр хорооллын иргэдийн өвлийн бэлтгэл ажлын гол үндэс болсон түлшээ бөөнөөр авч бэлтгэдэг цаг хугацаа тулчихсан энэ үед СШТ-ийг худалдахад тавих хязгаарлалтын бодлогыг яаралтай зогсоож, нэг тонн хүртэл хэмжээгээр борлуулдаг болгох зохицуулалтыг хийж түлш үйлдвэрлэгчид энэ чиглэлээр үүрэг өгөх



СШТ-ийг ашиг олох зорилготойгоор бөөнөөр авч дамлан худалдахаас сэргийлж, Сайн картыг хэрэглээнд хяналт тавих зорилгоор хэрэглэх нь нэг талдаа сайн арга хэмжээ болж байна. Гэхдээ картыг СШТ хэрэглэдэг айл бүрт яаралтай түгээх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.



Мониторингийн үр дүнд гэр хорооллын айл өрхүүдийн 14 хувь ханан пийшин ашигладаг бөгөөд ихэнх айл өөрсдийн төсөөллөөр барьдаг, ашиглалт, үйлчилгээний анхан шатны мэдлэггүй байдаг нь СШТ-ийг хэрэглэхтэй холбогдуулан гарч эхэлсэн бэрхшээлийн явцад тодорхой болсон. Иймээс ханан пийшин хэмээх халаалтын хэрэгслийг эрчим хүчний өндөр үр ашигтай, эдийн засгийн хувьд хамгийн хэмнэлттэй, эрүүл мэндэд хамгийн бага сөрөг нөлөөтэй барих, ашиглах техникийн стандартыг нэн тэргүүн боловсруулж, нэвтрүүлэх, сертификатжуулах шаардлага гарч байна. Энэ ажлыг мэргэжлийн байгууллага, судлаачид, иргэдийн хамтын ажиллагааны хэлбэрээр зохион байгуулж, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах.



Борлуулагч нарт

Худалдан авагч нар ямар ч төлбөрийн хэрэгслээр (бэлэн мөнгө, банкны карт, гар утасны шилжүүлэг гм) шинэ бүтээгдэхүүн болох СШТ-ийг худалдан авах боломжийг бий болгох



Худалдан авагч нарын дунд СШТ-ний хэрэглээний талаар гомдол, санал хүсэлтийг тусгайлсан дэвтэрт хаягийн хамтаар тэмдэглэж, ТТ түлшний үйлдвэрийн засвар үйлчилгээний төвд хүргүүлдэг болж хэвших



СШТ худалдан авагч нарын дотор мөнгөгүй учраас түлшээ авч чаддаггүй, мөнгөтэй болохоороо түлш авдаг эмзэг иргэд, айл өрх (асуулгад оролцогсодын 26.5%) их байгаа тул шөнө оройн цагаар СШТ худалдан авах боломжийг гаргаж өгдөг байх нь эмзэг бүлгийн иргэдэд бага ч гэсэн тус нэмэр болохоор байна.



Гэр хорооллын СШТ хэрэглэгч нарт



Агаарын бохирдлыг бууруулахад иргэн бүрийн идэвхтэй оролцоо хамгийн чухал бөгөөд нийгмийн хариуцлагын хүрээнд агаар хөрс, усны бохирдлыг аль болох багасгах, үнсээ битүү төмөр саванд бусад ахуйн хаягдлаас тусад нь салхинд хийсч бохирдлын эх үүсвэр болохоос зайлсхийн хадгалж, тогтмол хогийн цэг ачуулдаг болж хэвших



Болзошгүй угаартах тохиолдлоос сэргийлэх зорилгоор галлагааны хэрэгсэл болох зуух, пийшин, ханан пийшин, нам даралтын зуухандаа тогтмол арчилгаа үйлчилгээ хийж эвдрэл гэмтлийг (зуухны эвдрэл, гэмтэл, ханан пийшингийн цуурал, яндангийн цоорхой, утаа саагалт гэх мэт) нэн даруй засаж сайжруулах, Өөрсдийн хүчээр засах боломжгүй тохиолдолд Таван толгой түлш компанийн Засвар үйлчилгээний төвд борлуулагчаар дамжуулан дуудлага өгч засуулах, зөвлөгөө авч байх





СШТ-ийг хэрэглэх арга заавруудын дагуу зөв галлагаа хийж хэвших, бусдадаа түгээх, туслах



Бусад айл хөршүүдээ агаарын бохирдлыг үүсгэх аливаа буруу дадал хэвшил гаргах явдлаас сэрэмжүүлэх, зөв дадал хэвшлийг бий болгоход өөрсдийнхөндөө болон хөршүүддээ туслах, хориглосон нүүрс, автомашины дугуйг гэр сууцаа халаах зориулалтаар шатаахгүй байх, хууль бус үйлдэл гаргасан тохиолдолд шаардлага тавьж зогсоох эсвэл хорооны дарга, хэсгийн ахлагч, цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгддэг болох

УБ хотын агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг нийгэмд үйлчилдэг ТББ-уудад

УБ хотын агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд хийгдэж байгаа СШТ нэвтрүүлэх ажлыг тайлбарлан таниулах сурталчлахад идэвхитэй оролцож, өөрсдийн амьдардаг орчны айл өрхүүдийн санал, гомдол, хүсэлтийг ажил зохион байгуулж буй байгууллагуудад нэн даруй хүргэх, ажлын явц үр дүнд гарч буй бэрхшээл, доголдол, дутагдал болон тэргүүн туршлагыг шийдвэр гаргагчдад хүргэх зэргээр дэмжлэг үзүүлэх шаардлага нэн чухал байна.

  Агаарын бохирдлыг бууруулах талаарх бодлого, үндэсний хөтөлбөрийг сурталчлах, ухуулан таниулах ажилд иргэний нийгмийн байгууллагуудын идэвхитэй оролцоог бүрдүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах, тэдний үйл ажиллагааг дэмжих




Агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтэд хийсэн хөндлөнгийн мониторингийн үр дүнг олон нийтэд мэдээлэх, төсөв хөрөнгийн зарцуулалтын ил тод, шилэн байдлыг хангах чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаа явуулах шаардлагатай

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд



СШТ үйлдвэрлэгч, мэргэжлийн багийн судалгааны үндсэн дээр боловсруулсан Олон төрлийн зуух, пийшин, ялангуяа нам даралтын зуух, ханан пийшинд СШТ-ийг хэрхэн тохируулж хэрэглэх талаарх гарын авлага, сургалт сурталчилгааны материалуудын сурталчилгааг сонирхол татсан өвөрмөц аргаар нийтэд түгээхэд туслах, төрийн байгууллагуудаас энэ чиглэлээр явуулж буй бодлого арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

Иргэдэд СШТ-ний борлуулалтын цэгүүдийн байршил, СШТ-ийг олон төрлийн зуух, пийшинд галлах онцлог болон халаалтын хэрэгсэлдээ засвар үйлчилгээ хийх заавар зөвлөмж, галын аюулаас болон угаартах нөхцөл үүсэхээс урьдчилан сэргийлэх, шөнийн цагаар цахилгааны хөнгөлөлт үзүүлж байгаа үед цахилгааны хэт ачаалал үүсгэснээс үүдэн гарч болзошгүй цахилгаан хэрэгсэл халж шатах, гал түймэр үүсэхээс урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд эрүүл мэнд, амь насанд аюулгүй аргаар эрсдэлийг багасгах гэх мэт мэдээллийг Нийслэлийн МХГ, ОБГ, Эрчим хүчний зохицуулах хороо, сайжруулсан түлшний үйлдвэрийн мэргэжилтнүүдийн дэмжлэгээр бэлтгэн, байнгын давтамжтай түгээн дэлгэрүүлэхэд туслах



СШТ-тэй холбоотой утааны бүтэц, ялгарах химийн бодисын хоруу чанар, энэ талаар Монголын болон олон улсын лабораториудын шинжилгээний үр дүн, мэргэжилтнүүдийн тайлбарыг байршуулсан мэдээллийн эх сурвалжийн талаар байнга тогтмол мэдээлэх



Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам, Орчны Бохирдлыг Бууруулах Үндэсний Хороонд зориулсан бодлогын ерөнхий зөвлөмж

Агаар орчны бохирдлыг бууруулах чиглэлээр төрийн байгууллагуудын ажлын явц, үр дүнд ТББ-уудаар хөндлөнгийн мониторинг хийлгэх замаар гүйцэтгэлийг сайжруулах, төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах, ТББ, иргэдийн идэвхитэй оролцоог бий болгох замаар төрөөс гарах шийдвэрийг амьдралд ойртуулах шаардлага улам нэмэгдэж байгаа нь түүхий нүүрсийг хориглох, СШТ-ийг хэрэглээнд нэвтрүүлэх талаар 2019 оноос хэрэгжиж буй бодлогоос тодорхой харагдаж байна.



Цаашид Төрөөс ард иргэдийн амьжиргаанд шууд нөлөөлөл үзүүлэх шийдвэр гаргахын өмнө олон нийтээр хангалттай хугацаанд заавал хэлэлцүүлдэг эрх зүйн орчныг бүрдүүлж хэрэгжүүлэх. Нэгэнт нийгмийн

тулгамдсан асуудал болох орчны бохирдол, амь нас, эрүүл мэндэд сөрөг үр дагавартай бодитой асуудлыг шийдвэрлэх гэж зорьж байгаа тул санал болгож буй шийдлийн талаарх мэдээллийг олон нийтэд ил тод өгөх, урьдчилсан туршилт хийж иргэдийн хэрэгцээг хангаж буй эсэх, хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөө үүсэх эсэхийг магадлах, мөн хүхрийн давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл зэрэг эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг шаталтын бүтээгдэхүүний ялгарах хэмжээ, цаашид авах арга хэмжээний үе шат зэргийг нээлттэй мэдээлж, эх сурвалжийг заах шаардлагатай.



Аль нэг талыг баримтлах, сурталчилах гэхээс илүү шинжлэх ухаанч, олон талын эх сурвалжийг нээлттэй болгох, зорилтот бүлэгт тухайн мэдээллийг хялбар, ойлгомжтой, энгийн хэлбэрээр хүргэх зэрэг арга хэмжээг нийгэмд чиглүүлсэн бодлоготой уялдуулан төлөвлөдөг, зохион байгуулдаг болгох.



Иргэдийн бодит хэрэгцээ, шаардлага, санал хүсэлт, эрдэмтэд, судлаачдын судалгааны үр дүнг харгалзан үзэхгүйгээр гэнэтийн шийдвэр гаргадаг улс төрчдийн зохисгүй арга барилыг хязгаарлах шаардлагатай.

